



**МОНГОЛ УЛСЫН
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2009 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

┌
“Монгол Улсын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчид нэр дэвшигчийг сонгон шалгаруулах журам”-ыг шинэчлэн батлах тухай
└

Шүүхийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.6 дахь хэсэг, 63 дугаар зүйлийн 63.3 дахь хэсэгт заасныг удирдлага болгон Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчид нэр дэвшигчийг сонгон шалгаруулах журам”-ыг шинэчлэн баталсугай.

2. Энэ журам батлагдсантай холбогдуулан Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2002 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 53 дугаар тогтоол, уг журамд 2004 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсныг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.БАТДЭЛГЭР

ГҮЙЦЭТГЭХ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Н.ГАНБАЯР

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧ, ЕРӨНХИЙ ШҮҮГЧИД НЭР ДЭВШИГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хуулийн дагуу хуульчдаас Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын шүүх, дүүргийн шүүх, дагнасан шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчид нэр дэвшүүлэх, нэр дэвшигчдийг бүртгэх, шүүгч, Ерөнхий шүүгчээр томилуулахаар өргөн мэдүүлэх ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Шүүгч, Ерөнхий шүүгчид нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг бүртгэх, нэр дэвшигчдээс шүүгч, Ерөнхий шүүгчийг шалгаруулах, өргөн мэдүүлэх ажиллагааг нэр дэвшигчид эрх тэгш байх, ил тод, шударга байдлыг хангах зарчмын үндсэн дээр хэрэгжүүлнэ.

1.3. Шүүгч, Ерөнхий шүүгчид нэр дэвшигчийн эрх зүйн мэдлэг, ажил хэргийн чадварын талаар шалгалт авах, Ерөнхий шүүгч болон шүүгчийн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварыг шалгаж, дүгнэлт гаргах ажиллагааг Шүүхийн мэргэшлийн хорооны дүрмийн дагуу явуулна.

1.4. “Бүх шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигч” гэдэгт дээд шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд өрсөлдөхөөр нэрээ дэвшүүлсэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч, дагнасан шүүхийн шүүгч, түүнчлэн шүүгчийн албан тушаалд нэрээ дэвшүүлж байгаа хуульчид хамаарна.

Хоёр. Шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд өрсөлдөхөөр нэр дэвшүүлэх

2.1. Шүүхийн тухай хуулийн 28 дугаар зүйлд зааснаар дараах шаардлага хангасан Монгол улсын иргэн шүүгчид нэрээ дэвшүүлэх эрхтэй.

2.1.1. Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан болзлыг хангасан;

2.1.2. Ял шийтгүүлж байгаагүй;

2.1.3. Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан;

2.2. Анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид Шүүхийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-28.4-т заасан журмын дагуу нэр дэвшүүлнэ.

2.3. Шүүгч, Ерөнхий шүүгчид нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах үйл ажиллагааг шүүгч, Ерөнхий шүүгчийн орон тоо гарсан, бүрэн эрхийн хугацаа дууссан тухай бүр Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс /цаашид Ерөнхий зөвлөл гэх/ зарлан явуулна.

2.4. Шүүхийн тухай хуулийн 27 дугаар зүйлд зааснаар Ерөнхий зөвлөл бүх шатны шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалт явуулах тухай зарыг сонгон шалгаруулалт явуулах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

2.5. Сонгон шалгаруулалтын зард нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг бүртгэх хугацаа, шалгалт авах байр, өдрийг тодорхой заана.

2.6. Шүүгчийн шалгаруулалтад тэнцсэн нэр дэвшигч нь шалгалт өгсөн өдрөөс хойш 1 жилийн хугацаанд Ерөнхий зөвлөлийн ажлын албаны хүний нөөцийн жагсаалтад бүртгэлтэй байна.

2.7. Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд өрсөлдөхөөр нэр дэвшигчдэд зориулсан төлбөртэй сургалтыг Шүүхийн мэргэшлийн хороо болон Ерөнхий зөвлөлийн ажлын албанаас зохион байгуулж болно.

2.8. Шүүгч, Ерөнхий шүүгчээр томилуулахаар Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэхээс өмнө нэр дэвшигч нэрээ татан авах эрхтэй.

2.9. Шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд нэр дэвшигч нь дараах баримт бичгийг бүрдүүлж тухайн шүүхийн тамгын газар, хэлтэст өгнө. Үүнд:

2.9.1. Шүүгчийн албан тушаалд өрсөлдөхийг хүссэн өргөдөл /загвар, хавсралт 2/;

2.9.2. Шүүгчид нэр дэвшигчээс шаардагдах мэдээлэл, танилцуулга /загвар, хавсралт 3/;

2.9.3. Албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт /Монгол Улсын Их Хурлын 2007 оны 09 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт/;

2.9.4. Төрийн албан хаагчийн биеийн байцаалт, нэмэгдэл хуудас;

2.9.5. Нэр дэвшигчийн мэдлэг, ажил хэргийн чадвар, дадлага туршлага, ёс зүйн байдлын талаар тодорхойлж чадах 3 хүний тодорхойлолт /тодорхойлолтын загвар, хавсралт 4/;

2.9.6. Тухайн нэр дэвшигч ямар нэг албан байгууллагад ажиллаж байгаа бол ажил байдлын тодорхойлолт;

2.9.7. Их, дээд сургууль төгссөн диплом, мэргэжлийн үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

2.9.8. Ерөнхий боловсролын сургууль төгссөн гэрчилгээний хуулбар;

2.9.9. Магистр, докторын зэрэг хамгаалсан бол дипломын хуулбар;

2.9.10. Нотариат болон өмгөөлөх эрх авсан бол тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;

2.9.11. Хуульчийн сонгон шалгаруулалтын гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

2.9.12. “Хуульчийн үргэлжилсэн сургалтын журам”-д заасны дагуу багц цаг хангасан тухай тодорхойлолт /шүүгчид хамаарахгүй/;

2.9.13. Иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

2.9.14. 3х4 хэмжээний 2% цээж зураг /шүүгч бол нөмрөгтэй зураг/;

2.9.15. Эрүүл мэндийн дүгнэлт /загвар, хавсралт 5/;

2.9.16. Хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар /шүүгчид хамаарахгүй/;

2.9.17. Ял шийтгүүлж байгаагүй тухай цагдаагийн байгууллагын лавлагаа;

2.9.18. Сүүлийн 1 жилийн хугацаанд захиргааны болон сахилгын арга хэмжээ авагдсан эсэх тухай тодорхойлолт /Шүүгчийн хувьд Шүүхийн Сахилгын хорооноос, шүүхийн ажилтан бол тухайн шүүхийн тамгын газар, хэлтсээс, бусад нэр дэвшигчийн хувьд ажиллаж байгаа тухайн байгууллагаас нь авна/.

2.10. Ерөнхий шүүгчид нэр дэвшиж байгаа шүүгч сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлт, улиран томилогдохоор нэр дэвшиж байгаа Ерөнхий шүүгч сүүлийн 6 жилийн ажлын тайланг Ерөнхий зөвлөлийн ажлын албанд ирүүлнэ.

2.11. Шүүгчийн албан тушаалд шинээр нэр дэвшигч шалгалтын хураамж 10.000 төгрөг бэлнээр төлнө.

2.12. Шүүхийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд зааснаар нэр дэвшигчийг Үндсэн хууль, Шүүхийн тухай хуулийн шаардлагыг хангаж буй эсэхийг судалсны үндсэн дээр тухайн шүүхийн тамгын газар, хэлтэс бүртгэхдээ энэ журмын 2.9-д заасан баримт бичгийн бүрдлийг хангасан эсэхийг шалгана. /Бүртгэх хуудасны загвар, хавсралт 1/

2.13. Нэр дэвшигч нь харах, сонсох, өгүүлэхийн эрхтний болон сэтгэцийн хувьд шүүн таслах ажиллагаа явуулахад харшлах өвчин эмгэггүй байх ёстой. Нэр дэвшигч эрүүл мэндийн хувьд шүүн таслах ажиллагаа эрхлэн явуулахад харшлах өвчин эмгэгтэй эсэхийг эмнэлгийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн тодорхойлно. Харшлах өвчин эмгэгтэй нь тогтоогдвол шүүгчид нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах үндэслэл болно.

2.14. Нэр дэвшигчийн бүрдүүлсэн баримт бичгийг шалгах явцад шүүгчийн албан тушаалыг хашихад харшлах аливаа үндэслэл, шалтгаан тогтоогдвол бүртгэн авахаас татгалзсан үндэслэл бүхий хариуг тухайн шүүхийн тамгын газар, хэлтсээс өгнө.

2.15. Шүүхийн тамгын газар, хэлтэс шүүгчид нэр дэвшигчийг бүртгэн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан холбогдох баримт бичгийг Ерөнхий зөвлөлийн ажлын албанд хүргүүлнэ.

2.16. Ерөнхий зөвлөлийн ажлын алба нь шүүхийн тамгын газар, хэлтсээс ирүүлсэн нэр дэвшигчдийн баримт бичгийг нягталж, нэгтгэн бүртгэнэ. Бүртгэлийн явцад зөрчил илэрвэл Ерөнхий зөвлөлийн ажлын алба нь шүүхийн тамгын газар, хэлтэст мэдэгдэж холбогдох арга хэмжээг авна.

2.17. Нэр дэвшигч нь хуурамч баримт бичиг бүрдүүлж өгсөн нь илэрвэл түүнийг бүртгэлээс хасна.

2.18. Нэр дэвшигч тухайн шүүхийн шүүгчийн албан тушаалд нэрээ дэвшүүлж, бүртгүүлэх хугацаа дууссанаас хойш тухайн сонгон шалгаруулалтад өөр шүүхэд нэр дэвшихгүй.

2.19. Ерөнхий зөвлөлийн ажлын албаны хүний нөөцийн жагсаалтад бүртгэлтэй хүн шүүгчийн албан тушаалд дахин нэр дэвшүүлэх бол хавсралт 6-д заасан маягыг бөглөж, шинээр нэр дэвшиж байгаа хүний адил тухайн шүүхийн тамгын газар, хэлтэст бүртгүүлнэ.

2.20. Ерөнхий шүүгчид нэр дэвшүүлж буй шүүгч шинээр нэр дэвшиж байгаа хүний адил тухайн шүүхийн тамгын газар, хэлтэст бүртгүүлнэ.

Гурав.Шүүхийн Ерөнхий зөвлөлийн хуралдаанаар нэр дэвшигчийг хэлэлцэх

3.1. Шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасны дагуу Ерөнхий зөвлөл хуралдаанаараа Мэргэшлийн хорооны шалгалтад тэнцсэн нэр дэвшигчдийг хүн нэг бүрээр хэлэлцэж, санал нууцаар хураан, гишүүдийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг шүүгчээр томилуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж тогтоол гаргана.

3.2. Нэр дэвшигчийн тодорхойлолт, танилцуулгыг Ерөнхий зөвлөлийн ажлын албанаас гишүүдэд урьдчилан тараасан байна. Шаардлагатай гэж үзвэл Мэргэшлийн

хорооны дарга, гишүүд болон нэр дэвшигч, холбогдох бусад хүмүүсийг Ерөнхий зөвлөлийн хуралдаанд байлцуулж болно.

3.3. Нөөцөд бүртгэгдсэн нэр дэвшигчийг өөртэй нь зөвшилцсөний үндсэн дээр адил шатны өөр шүүхэд томилуулахаар Ерөнхий зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлж болно.

3.4. Сум буюу сум дунд, аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалд шалгалт өгч тэнцээд, нөөцөд байгаа нэр дэвшигч дүүргийн болон нийслэлийн шүүхийн шүүгчийн албан тушаалд өрсөлдөхөөр бол дахин шалгалт өгнө.

3.5. Дагнасан болон хяналтын шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд шалгалт өгч тэнцээд, нөөцөд байгаа нэр дэвшигч өөр шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд өрсөлдөхөөр бол дахин шалгалт өгнө.

3.6. Шүүгч нь адил шатны өөр шүүхийн шүүгчийн зарласан орон тоонд ажиллахыг хүссэн өргөдөл ирүүлсэн тохиолдолд нэр дэвшигчдийн хамт Ерөнхий зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

3.7. Ерөнхий зөвлөл нэр дэвшигчийг шүүгчийн албан тушаалд томилуулах тухай тогтоолоо 3 хоногийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

3.8. Монгол Улсын Ерөнхийлөгч Ерөнхий зөвлөлөөс өргөн мэдүүлсэн нэр дэвшигчийг шүүгч болон Ерөнхий шүүгчээр томилохоос татгалзсан тохиолдолд тухайн орон тоонд дахин сонгон шалгаруулалт зарлана.

НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛ

.... оны дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар...

.....хот, сум

..... шүүхийн /шүүгч, Ерөнхий шүүгч/-ид /аль нь болохыг зурах/ нэр дэвшүүлсэн овогтой-ны нь хууль зүйн дээд боловсролтой, нас хүрсэн, мэргэжлээрээ жил ажилласан, ял шийтгэгдэж байгаагүй байх тул Шүүхийн тухай Монгол Улсын хуулийн 29 дүгээр зүйлийг үндэслэн шүүгчид нэр дэвшигчээр бүртгэн авав.

.....шүүхийн тамгын /газар,хэлтэс/-ийн

дарга/...../

ӨРГӨДӨЛ

Шүүгчийн албан тушаалд нэрээ дэвшүүлэх тухай

..... овогтой-ын би Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйл, Шүүхийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Шүүгч, Ерөнхий шүүгчид нэр дэвшигчийг сонгон шалгаруулах журамд заасан болзол шаардлагыг хангасны учир өөрийн нэрийг..... шүүхийн шүүгчийн албан тушаалд дэвшүүлж байна.

Миний бие төрийн хариуцлагатай албан тушаалд өрсөлдөхийн тулд өөрийн талаарх шаардлагатай бүхий л мэдээллийг үнэн зөв, бүрэн мэдээлж, шүүгчид нэр дэвшигчээр бүртгэн авахыг хүсч өргөдөлөө гаргаж байна.

Миний өгсөн хариулт, мэдээллийн үнэн эсэхийг нягтлан шалгахыг Шүүхийн мэргэшлийн хороонд зөвшөөрч, миний талаарх үнэн зөв мэдээллийг Шүүхийн Ерөнхий зөвлөл, Шүүхийн мэргэшлийн хороонд өгөх эрхийг бусад холбогдох бүх хүнд олгож байна.

Шүүгчийн албан тушаалд өрсөлдөхөд шаардагдах дараах баримт бичгийг бүрдүүлэн хавсаргав.

1/ Шүүгчид нэр дэвшигчээс шаардагдах мэдээлэл, танилцуулга /загвар, хавсралт 3/;

2/ Албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт /Монгол Улсын Их Хурлын 2007 оны 09 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт/;

3/ Төрийн албан хаагчийн биеийн байцаалт, нэмэгдэл хуудас;

4/ Нэр дэвшигчийн мэдлэг, ажил хэргийн чадвар, дадлага туршлага, ёс зүйн байдлын талаар тодорхойлж чадах 3 хүний тодорхойлолт /тодорхойлолтын загвар, хавсралт 4/;

5/ Тухайн нэр дэвшигч ямар нэг албан байгууллагад ажиллаж байгаа бол ажил байдлын тодорхойлолт;

6/ Их, дээд сургууль төгссөн диплом, мэргэжлийн үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

- Ерөнхий боловсролын сургууль төгссөн гэрчилгээ;

- Магистр, докторын зэрэг хамгаалсан бол дипломын хуулбар;

- Нотариат болон өмгөөлөх эрх авсан бол тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;

- Хуульчийн сонгон шалгаруулалтын гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

- “Хуульчийн үргэлжилсэн сургалтын журам”-д заасны дагуу багц цаг хангасан тухай тодорхойлолт;

7/ Иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

8/ 3 x 4 хэмжээний 2% цээж зураг;

9/ Эрүүл мэндийн дүгнэлт /загвар, хавсралт 5/;

10/ Хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

11/ Ял шийтгүүлж байгаагүй тухай цагдаагийн байгууллагын лавлагаа;

12/ Сүүлийн 1 жилийн хугацаанд захиргааны болон сахилгын арга хэмжээ авагдсан эсэх тодорхойлолт;

Энэхүү өргөдөлд болон хавсаргасан баримт бичигт тусгасан бүх зүйлийг үнэн зөв, бүрэн мэдүүлсэн тул судлан үзэж, шүүгчид нэр дэвшигчээр бүртгэн авна уу.

Гарын үсэг /...../ он.... сар ... өдөр

Монгол улсыншүүхийн шүүгчийн албан тушаалд
өрсөлдөж байгаа нэр дэвшигч -ны -
ны танилцуулга

Нэг. Гэр бүлийн байдлын талаар

1. Ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр, төрсөн он, нас, хүйс, ам бүлийн
байдал, гэрийн хаяг

.....
.....
.....

2. Гэрлэлтийн байдал, гэрлэсэн бол гэр бүлийн хүний мэргэжил, хаана
ямар ажил эрхэлдэг, хаяг, утас

.....
.....
.....

3. Насанд хүрсэн тусдаа амьдардаг хүүхдүүдийн нэр, хаяг, утасны дугаар,
мэргэжил, ажлын газрын хаяг

.....
.....
.....

Хоёр. Мэргэжил, албан үүрэг, мэргэшлийн чиглэлийн талаар

4. Хууль зүйн их, дээд сургуульд буюу эрх зүйн мэргэжил дээшлүүлэх
дамжаанд багшилж байсан эсэх. Хэрэв тийм бол ямар сэдвээр хичээл заадаг,
сургууль, дамжааг тодорхой дурьдана уу.

.....
.....
.....

5. Урьд нь шүүгчийн албан тушаалд нэрээ дэвшүүлж байсан уу? Тийм бол
хэзээ, аль шүүхийн шүүгчид нэрээ дэвшүүлж байсан огноог бичнэ үү.

.....
.....
.....

6. Хуулийн сэдвээр тавьсан илтгэл, уншсан лекц, бичсэн болон хамтран
зохиосон ном, нийтлэлээ нэрлэнэ үү. /хэдэн онд/

.....
.....
.....
.....

7. Мэргэжлийн байгууллагад ажилласан байдал, ямар ажил үүрэг хариуцаж, ямар чиглэлээр түлхүү мэргэшсэнээ бичнэ үү.

.....
.....
.....

8. Төрийн бус байгууллагад ажиллаж байсан бол хаана ямар нэртэй байгууллагад ажиллаж байсан талаар бичнэ үү.

.....
.....
.....

9. Захиргааны болон сахилгын шийтгэл хүлээж байсан эсэх. Хэрэв тийм бол ямар зөрчил хэзээ гаргаж байсан, хэрхэн шийдвэрлэсэн талаар тодорхой бичнэ ҮҮ.

.....
.....
.....
.....
.....

Өөрийн талаарх мэдээллийг үнэн зөв, бүрэн бичсэн

Гарын үсэг /...../ он.... сар ... өдөр

ТОДОРХОЙЛОЛТ

Нэр дэвшигчийн тухай товч мэдээлэл:

Ургийн овог.....эцэг /эх/-ийн нэр
 нэр

Хаана, аль шатны шүүхэд нэрээ дэвшүүлж байгаа

Тодорхойлолт гаргаж байгаа хүний товч мэдээлэл:

Нэр

Ажил, албан тушаал

Ажлын болон гар утас

Гарын үсэг /...../ он.... сар ... өдөр

Нэр дэвшигчийн талаар өгөх тодорхойлолтод дурдвал зохих асуудлууд:

- Нэр дэвшигчтэй хэзээ, ямар хугацаагаар, хэрхэн хамтран ажиллаж байсан, эсвэл түүнд багшилж байсан тухай
- Хамтран ажиллах хугацаанд нэр дэвшигчээс гаргаж байсан хувийн зан байдал, идэвхи чармайлт, бусдаас ялгарах онцлог, ур чадвартай бол түүнийг нэрлэх
- Ажиллах хугацаанд хүрсэн гол үр дүн, бүтээсэн ажил үйлс /товч/
- Хуульчийн ёс зүйг сахиж ирсэн байдал, итгэлтэй байдал
- Шүүгчийн албан тушаалыг хашихад шаардлагатай дараах чадваруудыг нь ямар хэмжээнд та үнэлж байгаагаа дараах үнэлгээгээр үнэлнэ. (А-“шаардлагаас үлэмж дээгүүр”, В-“шаардлагаас дээгүүр”, С-“шаардлагын түвшинд”, D-“шаардлагаас зарим талаар доогуур”, F-“хангалтгүй”)

Бие даан шийдвэр гаргах чадвар	A	B	C	D	F
Эгзэгтэй үед харилцан ойлголцох чадвар	A	B	C	D	F
Идэвх, чармайлт, санаачилга	A	B	C	D	F
Ачаалалтай ажиллах, цагийг үр ашигтай хуваарилах чадвар	A	B	C	D	F

/Тодруулах шаардлагатай асуудал гарвал тодорхойлолт гаргасан хүнтэй холбоо барьж болно/

Эрүүл мэндийн дүгнэлтийн загвар, хавсралт-5

..... шүүхийн шүүгчид нэр дэвшигч-НЫ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДҮГНЭЛТ

20....оны...сарын...ны өдөр

д/д	Үзлэг, шинжилгээ	Үзлэг, шинжилгээ хийсэн огноо	Эмчийн дүгнэлт	Эмчийн гарын үсэг
1	Дотрын эмгэг			
2	Мэс заслын эмгэг			
3	Мэдрэл, сэтгэцийн эмгэг			
4	Чих, хамар, хоолойн эмгэг			
5	Нүдний хараа			
6	Халдварт өвчин			
7	Арьсны өвчин			
8	ДОХ-ын шинжилгээ			
9	Дүрслэх шинжилгээ	оношийн		
10	Цусны шинжилгээ			

ЕРӨНХИЙ ЭМЧИЙН ДҮГНЭЛТ: -ЫННЬ
 эрүүл мэндийн хувьд шүүн таслах ажиллагаа эрхлэхэд

(тэнцэнэ, тэнцэхгүй тухай дүгнэлтийг үсгээр тодорхой бичнэ)

ЕРӨНХИЙ ЭМЧ

Тэмдэг

..... Шүүхийн тамгын газар, хэлтэст

ӨРГӨДӨЛ

Шүүгчийн албан тушаалд нэрээ дэвшүүлэх тухай

..... овогтой-ынби Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйл, Шүүхийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Шүүгч, Ерөнхий шүүгчид нэр дэвшигчийг сонгон шалгаруулах журамд заасан болзол шаардлагыг хангажшүүхийн шүүгчийн албан тушаалд нэрээ дэвшүүлэн Шүүхийн мэргэшлийн хорооны оны сарын-ны өдрийн шалгалтанд тэнцэж, шүүхийн хүний нөөцөнд бүртгэгдсэн болно.

Өмнө нь шүүхийн шүүгчийн албан тушаалд нэрээ дэвшүүлж, өрсөлдөөд Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс олонхийн санал авч чадаагүй.

Иймд миний бие нь шүүхийн шүүгчийн албан тушаалд нэрээ дэвшүүлж байгаа учир нэр дэвшигчээр бүртгэн авахыг хүсч өргөдөл гаргаж байна.

Миний өгсөн хариулт, мэдээллийн үнэн эсэхийг нягтлан шалгахыг Шүүхийн Ерөнхий зөвлөлд зөвшөөрч, миний талаарх үнэн зөв мэдээллийг Шүүхийн Ерөнхий зөвлөлд өгөх эрхийг бусад холбогдох бүх хүнд олгож байна.

Шүүгчийн албан тушаалд өрсөлдөхөд шаардагдах дараах баримт бичгийг бүрдүүлэн хавсаргав.

1/ Ял шийтгэлгүй тухай цагдаагийн байгууллагын лавлагаа.

2/ Сүүлийн 1 жилийн хугацаанд захиргааны болон сахилгын арга хэмжээ авагдсан эсэх тодорхойлолт

Гарын үсэг /...../ он..... сар ... өдөр